

ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛ НОМЫН ОРШЛЫН ТИГ ХЭЛБЭР

С.Отгонбаяр*

* Өвөр Монголын их сургуулийн багш, доктор, дэд профессор

Хөрвүүлсэн: Л.Норовсүрэн

Түлхүүр үг: монгол ном, оршил, тиг хэлбэр.

Номын оршил бол гол зохиолын өмнө байршиж, номын зохион бүтээгдсэн өнгөрөлт, найруулж хэвлэгдсэн явц, эрдэм шинжилгээний эх сурвалж зэргийг тодорхойлон өгүүлсэн хэсэг болно. Нарийсган өгүүлбэл, оршилд номыг зохион бүтээж, найруулан туурвисан үзэл санаа, агуулгын товч хийгээд найруулгын хэвшил, жич эрдэм шинжилгээний үнэ өртгийг үзүүлэн харуулдаг. Агуулгын бүрэлдэцийн хувьд оршил нь номын тусламж зохиолд харьяалагдаж уншигчийн номын гол зохиолын материалыг ойлгон ашиглахад тусламж үзүүлж, номын тухай эл зүйлийн сураг зангийг хангана.

Монголчууд ном бичигтээ оршил бичих үзэгдэл наад захдаа Юаны гүрний үеэс эхэлснийг сурвалж бичгээс мөрдөн хайж болно. Түүнээс сүүлээр монголчууд ном бичих, найруулах, хэвлэх ажиллагаанд оршил нь номын агуулгын нэгэн чухал бүрэлдэхүүн болж, оршил, их оршил, бага оршил, ерөнхий оршил, хуудсан оршил, анх оршил, уул оршил, илэрхий оршил, оршлын оронд үүсгэл

өчил зэрэг нэрийдлээр улирч байв. Одоо үеийн монгол номонд оршил бичих нь түгээмэл үзэгдэл болов. Шүлгийн, тодорхойллын, таталган бичлэгийн, найрууллын, шүүмж өгүүллийн тиг хэлбэр бол түүний бичлэгийн гол тиг хэлбэр болж тодорч байна.

Нэг. Шүлгийн тиг хэлбэрийн оршил

Шүлгийн тиг хэлбэрийн оршил хэсэг нь олонхдоо шүлгийн түүвэрт харагдана. Иймэрхүү тиг хэлбэрийн оршил нь шүлэгчийн өөрийн оршил болно. Охор авсаархан бадаг шүлэгт шүлгийнхээ сүг сүнснийг хурайлан дуудаж байдгаас шүлгийн тиг хэлбэрийн оршлыг шүлэгчийн тунхаг гэхэд болмоор.

Шүлгийн тиг хэлбэрийн оршил нь сурвалж бичигт харагдана. Юань улсын үеийн хэл шинжилгээний эрдэмтэн, олон хэлний орчуулагч, яруу найрагч Чойжи-Одсэрийн 1305 оны орчим зохиосон "Зүрхэн тольтийн оршил шүлэг" бол манд олдсон хамгийн эртний шүлгийн тиг хэлбэрээр бичигдсэн оршил болно.

Шүлгийн тиг хэлбэрээр оршил бичих дадал одоо үед уламжлагдаж, одоо үеийн ном, онцгойлон шүлгийн номын оршлын чухал нэгэн тиг хэлбэр болов.

Шүлгийн тиг хэлбэрийн оршил нь голдуу шүлэгчийн хэрэг бодост болсон шүлэгчийн урмас сэтгэлгээг илэрхийлнэ. Жишээлбэл: На.Хөхшугуйн шүлгийн түүвэр "Соотой төрх"-ийн оршилд:

“Түүвэр минь

Түүгээд авсан сэтгэл минь

Түлхээд явуулсан хүсэл минь

Түүвэр минь

Түүхий нойтон шүлэг минь

Түүшээ зуусан хүлэг минь

Түүвэр минь

Бургилж урсан цус минь

Бөмбөрч унасан хөлс минь

Түүвэр минь

Алган дээр гэрэлтэх сувд минь

Ардын дунд дэлгэрэх шүр минь” гэж шүлэглэжээ. Түүнд шүлэгчийн түүвэртээ болсон нандигнал сэтгэлгээг илрүүлсэн юм.

Шүлгийн тиг хэлбэрийн оршил бол монгол номын оршлын удамшилт тиг хэлбэрийн нэг болно. Өнгөрсний монгол номын шүлэглэсэн оршил нь гол зохиолын агуулга удирдахаар голлуулж, хааяа бас зохиогч, найруулагч, орчуулагчийн үзэл бодлыг цухуйлгах, зохиож найруулж, орчуулсан учир шалтгааныг тодорхойлохоор дэдлүүлж байсныг нь На тангийн “Алтан эрихийн оршил”, Хээшингийн “Тай шангийн тохиолдуулан хариулах сургаалын бичиг”-ийн оршил, “Гүнгийн зуугийн гэгээний сургаал”-ын оршил шүлэг зэргээс гэрчилнэ. Илрүүлэх арга барилын хувьд тэд нарын шүлэглэсэн оршил нь голдуу ахуйч хэлбэртэй. Одоо үеийн номын шүлэглэсэн оршил нь шүлэгчийн хэрэг бодост болсон урмас сэтгэлгээг илрүүлэхдээ харин бэлгэдэл аргыг зонхи хэрэглэх болжээ.

Хоёр. Тодорхойлол тигийн оршил

Ном зүйчид номын тусламж зохиолыг түүний үйлдэл чадавхиар нь ялгах шинж бүхий тусламж зохиол, тодорхойлох шинж бүхий тусламж зохиол, лавлах шинж бүхий тусламж зохиол гэж хуваарилдаг¹. Тодорхойлол тиг хэлбэрийн оршил нь номын тодорхойлох шинж бүхий тусламж зохиолд харьяалагдаж, найруулсан ном, найруулан туурвисан ном, эсхүл тусгай туурвилд холбогдсон зүйлсийг тодорхойлох үйлдэл чадавхитай. Тодорхойлол тиг хэлбэрийн оршил нь “гол зохиолын бичиж хэвлэгдсэн, уламжлагдаж тархсан ба гол бүтээлд холбогдох бусад учрууд, бусад гол зохиолын агуулга, үзэл санаа, урлагийн тодорхойлолор өгүүлэгдэхүүн болгодог”². Түүнийг бид оршил зохиогч гол цогцоор нь найруулагчийн тодорхойлол, хэвлүүлэгчийн тодорхойлол, зохиогчийн тодорхойлол гэж ангилж болно.

Найруулагчийн тодорхойлол нь голдуу олон хүний бүтээлийг найруулж, эмхтгэсэн номонд харагдана. Найруулагчаас бэлэн материал, сурвалж бичиг, зохиол бүтээл зэргэсийг хаман цуглуулж, шилэн сонгоод шинэ нэгэн номыг найруулан хэвлүүлэх үед эмхтгэн найруулсан номондоо холбогдсон зүйлсийг тодорхойлон ярих хэрэгцээнээс найруулагчийн тодорхойлол буй болдог. Найруулагчийн тодорхойллыг найруулагч голлон бичнэ. Олонхдоо оршлын ард “Найруулагчаас”, “Найруулах комиссоос” гэж найруулагчийн гарлыг тодотгосон байдаг. Найруулагчийн тодорхойллын жишээнд бид “Хорьдугаар зууны дундад улсын монгол уран зохиолын сэтгүүлийн дээж бичиг”-ийн “Үүсэл өчил”-ийг дурдаж болно. Тус “Дээж бичиг”-ийг “үндэстний

соёлоо хамгаалах ухамсар"-аар 1998 оноос эхлэн сэдэн үүсгэсэн юм. "Дээж бичиг" нь 1926 оноос 2000 он болтолх манай улсын монгол уран зохиолын сэтгүүл ба уран зохиолын булантай сэтгүүлд нийтлэгдсэн хамгийн шилдэг зохиол, цаг цагийн төлөөлөх чанартай бөгөөд нөлөөлөх үйлдэлтэй бүтээлийг шилж, 60-70 боть ном болгон хэвлүүлэхээр төлөвлөсөн тул энэхүү томоохон "барилга"-ын оршил нь ч нэлээд урт болж билээ. Тус оршилд « "Дээж бичиг"-ийн дээжилсэн агуулга ба цагийн хэмжээ хязгаар», «"Ажил өрнүүлэх хүчний тухай" чөрхлөн найруулсан стилийн хэмжээ ба зарчим», "Ажлаа өрнүүлэхийн алхам дараалал", "Найруулах ажлын бодит явц", "Хэвлэх ажлын тухай", "Тархаах ажлын төсөв", "Тус номыг хэвлэх сүйтгэлийн аж ахуйн ирэлт", "Зохиол шилсэн үндэсний баримжаа", "Найруулан хэвлэх ажлын гүйцэтгэл ба зарчим" зэрэг агуулга хамрагджээ. Эдгээр агуулгад дээж бичгийг найруулахын ач холбогдол, ажил өрнүүлэх алхам дараалал, зохиол шилэх цагийн хязгаарлал, зохиол шилэх стилийн хэмжээ, зохиол шилэх үндсэн баримжаа зэрэг нь нэгд нэгээр нямбай тодорхойлогдсон юм. Бодитойчилбал, зохиол шилэх үндсэн баримжааг тодорхойлохдоо:

1. Агуулгаар эрүүл чийрэг, санаа гүнзгий зохиолууд
2. Нийгмийн нөлөө сайн, ардын дунд үндэслэсэн зохиолууд
3. Үг хэллэг нь баялаг, яруу сайхан, санаа уран зохиолууд
4. Уран сэтгэмжийн гоо сайхны хүртээл болмоор зохиолууд
5. Түүхийн их үнэ цэнэтэй зохиолууд гэсэн байдаг. Найруулагчийн тодорхойл-

лыг номыг эмхтгэн найруулсан хүн бичдэг. Үүнд хэвлэлийн хорооны гүйцэтгэсэн найруулагч буюу нийгмийн гүйцэтгэсэн найруулагч байж болно. Гэвч хэвлүүлэгчийн тодорхойллыг заавал хэвлэлийн хорооны хамаа бүхий найруулагчаас хэвлэлийн хороог төлөөлж бичдэг.

Хэвлүүлэгчийн тодорхойлол нь "Хэвлүүлэгчийн үг", "Хэвлүүлэгчийн тодорхойлол", "Дахин хэвлүүлэгчийн тодорхойлол" зэрэг хэлбэрээр оршдог. Түүнд хэвлэж бүхий номын хэвлэлийн үндэслэл, засалтын зарчим зэргийг тодорхойлохоор голлодгоос охор авсаархан бичлэгийн намбыг хөөцөлддөг. Жишээлбэл, 1957 онд Өвөр Монголын Ардын хэвлэлийн хорооноос хэвлэсэн "Хөх судар"-ын "Дахин хэвлүүлсэн тодорхойлол"-д "Манай эдүгээ хэвлүүлсэн 3 дэвтэр бол монгол утгын сургаалын хурлын хэвлэлийг үндэслэж, бусад хэвлэл ба гар бичмэлийг анхааралдаа авч, үг үсгийн талын алдаа ташааг нь залруулж хэвлүүлсэн юм" гэжээ. Бас жишээлбэл, 1979 онд Өвөр Монголын Ардын хэвлэлийн хорооноос хэвлэсэн "Монгол уран зохиолын дээж зуун билэг оршив" гэдэг номыг Ц.Дамдинсүрэн найруулж, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын шинжлэхүй ухаан ба дээд боловсролын хүрээлэнгээс 1959 онд Улаанбаатарт хэвлүүлэв. "Энэ удаа бид дахин хэвлүүлэхдээ зарим зохиолыг манд олдсон өнгөрсний зохиолуудтай харгуулж үзээд, илэрхий хэвлэлийн алдаа мадаг гэж бодсон зарим үг үсгийг засч, нэгдэлгүй байсан зарим нэрсийг аль чадахаар нэгтгэх гэж оролдсоноо мэдэгдье" гэжээ.

Хэвлүүлэгчийн тодорхойлол дахь хэвлэлийн үндэслэл, засалтын зарчим

зэргийн тодорхойлол нь голдуу дахин хэвлэсэн номонд харагдана. Бар хэвлэлийн улиран хувьссан явцыг дахин хэвлэлд тодорхойлон бичих нь уул хэвлэл ба дахин хэвлэлийн хоорондох агуулга бүрийн тоо жич үсэг бичгийн талаарх ялгааг тодруулахад маш ач тустай юм. Тэр нь хүмүүсийнхээр зүйн үүднээс номын бар хэвлэлийн эх сурвалж хийгээд улирал хувьслыг судлахад итгэмжтэй сураг зангийг хангаж чадна.

Н айруулагчийн тодорхойлол ба хэвлэгчийн тодорхойлолтой харьцуулбал зохиогчийн тодорхойлол нь бичлэгийн хувьд өөр ба хүнчилсэн бичлэгэнд тооцогдоно. Түүнд хувь хүний бүтээлийн туурвин бүтээсэн явц, бүтээлд ашиглагдсан эх материалын ирэлт, зохиол бүтээлийн бүтэц зохиомжийн тохируулга, жич Б.Бүрэнбэхийн “Зөн мэдрэхүй шүлэг зүй”-дээ бичсэн оршил, Б.Гэрэлтийн “Монгол зохиолын онол өгүүлбэрийн өв шүүлт”-дээ бичсэн оршил зэргээс ойлгож болно. Жишээлбэл: Б.Бүрэнбэхийн оршилд “Би уул товхимлоо агуулгыг үндэслэн хоёр ангилан найруулсан байна. Түрүүчийн хэсгийг шүлэг зүй хэмээж, сүүлчийн хэсгийг одоо үеийн монгол шүлгийн тухай шүүмж хэмээн нэрийджээ” гэсэн ба Б.Гэрэлтийн оршилд «Энэ удааны “өв шүүлт”-эд агуулгын багтаамж өргөжиж, дотроо 5 анги салган ангилж, тэргүүн ангид эртний эрдэмтэй лам нарын төвд, монгол хоёр хэлээр туурвисан өгүүллүүдийг хурааж, дэд ангид эртний монголчуудын хятад хэлээр зохиосон онол шүүмжүүдийг оруулаад, монгол бичигтний монгол хэлээрээ бичсэн онол өгүүлэхүйн бүтээлүүдийг гутгаар ангид дээд, дундад, доорд гурван ангилж

жагсаагаад, дөтгөөр ангид монгол утга зохиолын онол судлалд шууд холбогдох улс төр, гүн ухаан, түүх шашин, соёл боловсрол, сурган хүмүүжлийн тухай төлөөлөгч чанар бүхий өгүүллүүдийг түүн оруулав» гэсэн нь цөм номын бүтэц, зохиомжийн тохируулгад хийсэн тодорхойлол болох юм. Тодорхойллын тиг хэлбэрийн оршил нь бусдач шинжийг эрхэмлэж, тодорхойлж бүхий зүйлсийнхээ үнэн бодитой байхыг хөөцөлддөг.

Гурав. Сул тэмдэглэлийн тиг хэлбэрийн оршил

Хасбуу түүний “Шинэ орчуулсан Хун Ляу Лян бичиг”-ийн оршилдоо “Тийм бөгөөс би нэгэнтээ ертөнцийн хүн болон төрсөн тул ертөнцийн жам ёсон хүний үйлийн үрээс хэрхэж хэлтрэн чадах аж. Тийнхүү охиловч бээр тус нь үгүй болсон тул, огт аргагүй больё. Огт аргагүй болсонд би одоо хэрхэмүй хэмээн эргэцүүлэн бодвоос мөнхүү эртний хүний бичгийг үзэн, сэтгэлээ засч энэ үед орчуулан бичиж биеэ саатуулахаас өөр аргагүй”³ гэж тэмдэглэжээ. Тэмдэглэлд Хасбуугийн “Ертөнцийн жам ёсон”-д аргадсан сэтгэлгээ ба “Хун Ляу Лян бичиг”-ийг орчуулан бичсэн шалтгаанд тушаалт хийв. Ямар нэгэн хэв загварт баригдалгүй санааны аяар бийрийг татлах чөлөөт бичлэг нь сул тэмдэглэлийн онцлогийг харуулав.

Санаа илтгэмжийн хэрэгцээгээр бичлэгийн салаа намааг ургуулж, санаа бодлын аяар хуудасны урт охрыг тогтоох бол сул тэмдэглэлийн тиг хэлбэрийн оршлын гол онцлог болно. Үүнийг бид амьлаг бичлэг гэж хураангуйлж болно. Агуулгын хувьд тодорхойллын тиг хэлбэрийн оршил нь номын нэр,

хуудасны хэмжээ, бичлэгийн явц, эх материал, бүтэц зохиомжийг тодорхойлохоор голдсон байхад, сул тэмдэглэлийн тиг хэлбэрийн оршил нь харин зохиогчийн амьдралын өнгөрөлт, зан ааль, зохион бүтээлгийн ар үзэгдэл, зохиол бүтээлийн хэв намба зэргийг танилцуулахаар голдоно. Жишээлбэл: профессор Чойжинжавын "Монгол хэлний найруулгын зүй" (Ү.Наранбат) гэх ганц сэдэвт зохиолд бичсэн оршилд «Би Наранбат залуутай анх 1958 онд танилцсан билээ. Тэр үед Наранбат Өвөр Монголын их сургуулийн Монгол хэл бичиг, утга зохиолын салбарт шалган орж ирсэн, хэл амандаа хурц, дуу шүлэгт авьяастай, шар хув зүстэй, шагхийсэн залуу байж билээ. Нэг мэдэхэд 40 гаруй

жилийн өмнөх хэрэг болчихжээ. Манай сургуулийн Монгол хэлний салбар, их дээд сургуульд хэрэглэх монгол хэлний сурах бичиг найруулахын төлөө, 1960 оноос хөдөө явж хэл аялгуу байцаах ажил хийсэн юм. Тэгэхдээ Цэнгэлтэй профессорын удирдлагаар авианы зүй, хэлний зүй, үгсийн сан, найруулга зүй гэх мэт хэдэн дугуйланг хуваан, багш оюутан хамтран ажиллаж байсан бөгөөд оюутан Наранбат, Тэгшдүүрэн багшийн удирдсан найруулга зүйн дугуйланд ажиллаж байсан нь түүний нэг насаараа зүтгэх эрдмийн хөөцөлдүүлгийнх нь эхлэлт болсон аж» гэжээ. Тус оршил бол

бусдын бичсэн оршил болно. Оршилд оршлын зохиогчоос номын зохиогчтой танилцсан явц ба зохиогчийн ур авьяас, ажил мэргэжил, оролдлого хөөцөлдлийн тухай товч тодруун танилцуулга хийжээ. Хүүхдийн зохиолч Хасбарсын "Дундад улсын одоо үеийн монгол үндэсний сонин мэдээний ажлын зүтгэлтэн" (Мандал) номд бичсэн оршил ч иймэрхүү онцлогтой байгаа. Энэхүү 5 мянгахан

үсэгтэй оршилд Мандалын төрсөн он жил, төрсөн нутаг ус, ажиллаж өнгөрсөн байгууллага, бүтээж өнгөрсөн зохиол, "Зан яаруу, хөл хөнгөн" зан ааль жич сурвалжлага хийх аян дахь хатуу бэрх учрал зэргийг нэгд нэгээр тоочив. Л.Одсэрийн "Уулын намар" (Цэдэндорж) өгүүллэгийн түүвэрт бичсэн оршлоо «Цэ-

дэндорж хүний орчлонгоос салаад долоон жил болчихлоо. Дөч өнгөрсөн насандаа үхэл дэрэлсэн хүн нүд анихаасаа өмнө юу бодохгүй вэ! Хүний орчлонд амьд явахаас өөр сайхан юм юу билээ? Үүнийг хэлэхгүй, дөнгөж 40 өнгөрмөгц дөрөө орхиод явна гэдэг чинь амьд сэрүүн үеийн аль бүхнээ хагас дутуу хаяад явна гэсэн үг. Тэр бүхний дотор Цэдэндоржид авч хэлбэл хамгаас илүү хаяж төвдөхгүй зүйл нь юу байсныг би сайн мэднэ. Энэ насандаа аргалаад нэг ном гаргачихвал үхэвч гомдолгүй гэж тэр аль эрт зохиолч болох хүсэлдээ сөхрөн ярьж байсан юм» гэж эхлүүлсэн

«

Агуулгын хувьд тодорхойллын тиг хэлбэрийн оршил нь номын нэр, хуудасны хэмжээ, бичлэгийн явц, эх материал, бүтэц зохиомжийг тодорхойлохоор голдсон байхад, сул тэмдэглэлийн тиг хэлбэрийн оршил нь харин зохиогчийн амьдралын өнгөрөлт, зан ааль, зохион бүтээлгийн ар үзэгдэл, зохиол бүтээлийн хэв намба зэргийг танилцуулахаар голдоно.

»

байлаа. Залгаад Цэдэндоржтой танилцсан явц, Цэдэндоржийн зохион бүтээлгийн явц, "Уулын намар"-ын ном болсон өнгөрөлт зэргийг бичив. Жишээнээс ажиглавал, сул тэмдэглэлийн тиг хэлбэрийн оршил нь бичлэгийн хараагаа зохиолч гол цогцод шилжүүлж, хүүрнэхээр гол илэрхийлэх арга барил болгон хааяа уянгалах ба өгүүлэхээр хавсрамж болгодог аж.

Дөрөв. Найрууллын тиг хэлбэрийн оршил

Тодорхойллын тиг хэлбэрийн оршил нь зохиол бүтээлээр гол өгүүлэгдэхүүн болгоно. Сул тэмдэглэлийн тиг хэлбэрийн оршил нь зохиогчоор гол өгүүлэгдэхүүн болгоно. Найрууллын тиг хэлбэрийн оршил нь уянгалахаар гол илрүүлэх арга барил болгосноос түүний өгүүлэгдэхүүн нь харин баян цогцын сэтгэлгээ байжээ.

Найрууллын тиг хэлбэрийн оршлыг дурдахтай зэрэг "Үүлс" түүвэрт А.Сундуйн бичсэн оршил "Үүлний түрүү салхи"-ийг өөрийн эрхгүй санагдуулж байна. Түүвэрт сонгогдсон 24 хэсэг "үүл"-д зориулж бичсэн энэхүү оршил нь гоц сайхан найруулал болж хүмүүст таашаагджээ. Тус оршлыг "элдвийн үүлсийг нэг дор жагсааж тавиад товхимол болгосон явдал бол адил нэгэн гарчгаар байгалийн үзэгдлийг дүрсэлсэн зохиол бичиж, сэтгэлгээгээ уянгалах бичлэгийн аргыг залуучуудад сургая гэж санасан", "Үүлс"-ийг эмхтгэснийхээ зорилгоо тодорхойлж, санаагаа яриад зуршил ёсоор өнгөлж чимсэн хэдэн үг ярихын төлөөнөө бичжээ". Оршилд "Үүлс"-ийг сонгосон баримжаа (товхимолд орсон шүлэг зохиолуудыг үүлээр сэдэвлэсэн

төдий биш, заавал үүлээр гарчигласнаар чанга баримжаа болгов). "Үүлс"-ийн утга сэдэвлэхүүн ("Улаан үүл") гэвэл хувьсгалын бэлгэ тэмдэг болж, "Хар үүл" гэвэл тэрслүү хүчний төлөөлөл болж байснаа, "үүлс" одоодоо "хар үүл"-ээр ардчиллын сүр хүчний магтаал болгож, "улайсан үүл" хуучин нийгмийн хавчигдлын дурьтгал болсон.

Энэ бүхнийг ярихдаа урлагийн авцал ба бичлэгийн онцлог хэмээн ялгасангүй, утга санаа, агуулга найруулга, зохиомж дараалал, урлаг онцлог хэмээн угсуруулан тавьжээ. Эдгээрт тодорхойлсон ба өгүүлсэн элемент бага бус агуулагдана. Гэвч оршлын зохиогчоос эдгээр элементийг оргилом, цалгилам сэтгэлгээгээр хэлхэн уянгалуулснаас тус оршлыг нэгэн гоц сайхан найруулал гэж хэлэхэд сэжиг төрүүлэхгүй болгожээ. Тодорхойлол ба өгүүлэл нь оюуны шинжээр товгор, найруулал нь хариу сэрлийн шинжээр давуулаг. Гэвч оюу ба сэрэл хоёр нь ус тос шиг нийлшгүй биш юм. Хоёулыг ур дэмээр уясгалан нийлүүлэхэд хүрвэл найруулал тиг хэлбэрийн оршил ч оюун сэрэл хоёрыг хослуулсан учиртай сайхан бүтээл болж чадна. Гэвч үүнийг хэлэхэд хялбар хийхэд хүчир юм.

Одоо үеийн монгол номын оршилд найрууллаар бичсэн жишээ мундахгүй. Профессор Б.Бүрэнбэхийн "Б.Бүрэнбэхийн шүлгийн сонгомол" хэмээх номдоо бичсэн "Өөрийн оршил", профессор Сүеэгийн "Оюуны цэцэгсийн баглаа"-д бичсэн оршил, Баягууд Уранбилэгийн "Буур уулсын зүүд" шүлгийн түүвэртээ бичсэн оршил зэрэг бол цөм яруу уянгалан найруулал болно.

Тав. Өгүүлэл шүүмжийн тиг хэлбэрийн оршил

Өгүүлэл шүүмжийн тиг хэлбэрийн оршлын гол өгүүлэгдэхүүн бол текст бие болно. Зохиогчийн хувьд иймэрхүү тиг хэлбэрийн оршлын олонх нь бусдын оршилд тооцогдоно. Бусдын оршлыг зохиогч өөрөө биш, харин бусдыг урьж бичүүлдэг. Номын алдас, оношийг сөхөн шүүх бол өгүүлэл, шүүмжийн тиг хэлбэрийн гол үүрэг болно. Алдас оношийг сөхөн шүүх явц бол ном бичгийг хүлээх – амтархах – шүүмжлэх явц мөн. Үүнд оюунч танилтын явц шаардагдана. “Сөхөн шүүгч” нь бодитой нэгэн номын энгийн жам хуулийг мөрдөн илрүүлдгээс энгийнээс онцгойд хүрч, онцгойгоос дахин энгийнд буцах бол өгүүлэл шүүмжийн тиг стилийн оршлын зохиомж сэтгэмжийн ердийн мөрдөл болно. Зохиолч Аянга “Адуун төвөргөөн сондортой алтан зул цэцэг” (Ангит) өгүүллэгийн түүвэрт бичсэн оршилдоо: “Ангитын энэ түүврээс бид чухам юуг олж харах вэ?” гэвэл утга санааны хувьд мөхөл сөнөлийн ухамсар, урлагийн талаарх ахуйч үзлийн арга барилыг огоорон тэвчсэн бэлгэдлийн шинж, сэтгэлийн талаарх цөхрөн мухардсан гунигт жүжгийн хандаш зэргийг олж харж болно” гэж өгүүллэгийг хүлээн амтархсан сууринд зохиолын утга сэдвийн ерөнхий хандаш ба илрүүлэх аргын талаарх амжилтыг үнэлэн нотлов. Оршлын төгсгөлд: “Ангитад бид юу сануулах хэрэгтэй вэ? Тус түүврийг ажиглавал, илтгэх аргын талаарх тэг цулгүй байдал, агуулга утга санааны талаарх нарийн шаргаалт дутагдаж байгаа байдал ч нэлээд илхэн харагдаж байгаа” гэж алдагдалтай талыг ч дурдан

сануулжээ. Тус жишээнээс бид Аянгын шүүмжлэн өгүүлж буй өгүүлэгдэхүүндээ оюунч шаргаалт хийж оновчлог эзэмдэлтэй болсон нь илхэн харагдана.

Номын алдаш оношийг сөхөөн шүүхэд магадлал чухал байрыг эзэлнэ. Бодит байдалд үндэслэж, онол ёсонд дулдуйдаж, онолт, баримт, нотлолтоор дамжин текст биед зөв оновчлог муулал хийх бол өгүүлэл шүүмжийн тиг хэлбэрийн оршлын товойсон нэгэн онцлог болно. “Монгол үндэстний одоо үеийн шүлгийн сонгомол” (1949-1985) номын оршилдоо профессор Б.Бүрэнбэхээс “Монгол уянгын шүлэг дөчөөд жилийн хөгжлийн замдаа хэдийгээр алдах онохтой, асхан муруйтай явсаар ирсэн боловч амжилт бүтэмж бол товгор юм” гэх магадлал хийжээ. Энэхүү магадлал нь монгол үндэстний одоо үеийн тавиад жилийн шүлэг бүтээлийн бодит үйлдэлгэд үндэслэсэн бөгөөд оршлын зохиогчийн бат зузаан онолын боловсролд түшиглэсэн юм.

Яруу найраг дахь нийгмийн дээд хүслэн, монгол шүлгийн уянгын цогц, урлагийн шинэ эрэл зэрэг өгүүлэлтээр дамжин гүйцэтгэгдсэн энэхүү нотлол нь итгүүлэх хүчнээр тун чанга болжээ. Шүлэгч Л.Одсэрийн “Эргийн модод” (У.Буян-Өлзий) шүлгийн түүвэрт бичсэн оршилдоо «У.Буян-Өлзийн шүлэг “цагаан” шүлэг” гэх магадлал хийжээ. Залгаад “Цагаан шүлэг”-ийн тухай өөрийн үзлээ дэлгэж, “үнэнийг хэлэхэд шүлэгт уснаас цааш юм мунгүй харагдах боловч арай удмын уршиг биш шиг санагдах юм. “Цагаан” шүлэг бүр ус биш, эрээн шүлэг ч бүр тос биш. Харийн “ус”-аар усалсаар л ус боловч тос болчих ёс гэж арай үгүй. Буян-Өлзийн шүлэг

“цагаан” боловч шөлтэй, тостой монгол шүлэг» гэж өгүүлэв. Өгүүлэлтэд “цагаан шүлэг”-ийн удам, “цагаан шүлэг”-ийн хувь заяа, жич “цагаан шүлэг”, “эрээн шүлэг”-т болсон үзэлт ухвараа дүрслэгээр дэлгэж, “цагаан шүлэг”-ийг өмгөсөн хэлбэрийг ил гаргав. Энэ бол У.Буян-Өлзийн шүлгийн тухай зөвтгөл ба тухайн үеийн нэг бүлэг “цагаан шүлэг” бичдэг шүлэгчдийн амжилтын баримт болсон юм.

Номын алдаш оношид зөв оновчлог магадлал хийхэд оршлын зохиогчийн боловсрол ба хэр төвшин нь шийдвэрлэх үйлдлийг үзүүлнэ. Үнэнээс зөвийг эрэх овор, гол оршил ба дэд оршлыг ялгах чадвар зэрэг нь оршлын зохиогчийн боловсролын хэмжээг харуулна. Боловсрол сайтай оршлын зохиогч нь сая номын үнэ өртгийг илрүүлж, зөв оновчлог магадлалыг хийж чадна. Судлаач Ж.Ренчиндорж “ерээд он болж ирээд найрууллын зохион бүтээл халуунтай, эрчимтэй хөгжив” гэх өртгийн магадлал хийжээ. Өнөөдөр бид энэхүү магадлалыг зөв гэж үзэхэд хүрвэл, Ж.Ренчиндоржийн ерээд оны монгол найрууллын зохион бүтээлгийн үйлдэлгэд тодорхой эзэмдэл байсныг нотлохын хамт, түүний “Шинэ найруулал”-ын гоо сайхны үндсэн онцлогт суурилсан онолын боловсролыг ч хөнгөвчлөн үзэж болохгүй юм. Гоо зүйтүүхийн үзэлтээр номын үзэл санааны гүнцийг уудлах; үзэлтдээ үндэслэл хангах биш, харин номын үндэслэлээр үзэлтээ удирдан гаргах; өргөслөөр биш олон талаар сүвэгчилж, гол хийгээд дэд, үзэгдэл хийгээд мөн чанарыг тодруулах бол өгүүлэл шүүмжийн тиг хэлбэрийн оршлын үндсэн шаардлага болно.

Тус өгүүлэлд одоо үеийн монгол номын оршлын тиг хэлбэрийг таван талаар шинжиллээ. Оршилд үүнээс ондоо тиг хэлбэр бас байж болох боловч тэдгээр нь надад найдлага биш шиг санагдсан тул тус өгүүлэлд орхигдуулсныг тэмдэглэе. Номын оршлыг чухам яаж бичвэл зохистой вэ? Тус өгүүлэл нь энэхүү асуудлыг шийдвэрлэхээр зорилго болгоогүй.

Энд профессор Сүеэгийн “Намайгийн (миний) өгүүлэл шүүмжийн түүвэр”-т бичсэн оршлоос нэг бадгийг сийрүүлъя: “Оршилд заавал гол өгүүлэл-тээ товойлгож, мөн чанарт нь хүрэхүйц жам хуулийг сүвэгчлэн гаргаж, зохиогч ба уншигчиддаа тус бүтээлийг дахин боловсруулах буюу залган уншихад удирдамжийн үйлдлийг үзүүлж, битүү оньсыг нээх билгийн түлхүүрийг атгуулбал зохино”. Энэ бадаг үг л манай оршлыг чухам яаж бичих, юуны төлөө бичихийн тухайд сэнхрүүлэл болж мэднэ.

Ишлэл

¹ Дорнотэнгэр. 2000. Шүүмжлэлийн чадавхи – өвөрмонголчуудын утга зохиолын судлалын тухай их зүйлийн шинжилгээ. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 188 дахь тал.

² Гэрэлт Б. 1985. Монгол зохиолчдын шүүмж зохиолууд (1721-1945). Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 35 дахь тал.

³ Сүеэ. 2005. Намайгийн өгүүлэл шүүмжийн түүвэр. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 7 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

Резюме

1. Дорнотэнгэр. 2000. Шүүмжлэлийн чадавхи – өвөрмонголчуудын утга зохиолын судлалын тухай их зүйлийн шинжилгээ. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо.

2. Гэрэлт Б. 1985. Монгол зохиолчдын шүүмж зохиолууд (1721-1945). Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо.

3. Сүюүгэ. 2005. Намайгийн өгүүлэл шүүмжийн түүвэр. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо.

В данной статье автор излагает сделанную им же классификацию прологов к произведениям. На основании анализа многочисленных предисловий автор пришёл к выводу, что самыми распространёнными являются следующие прологи: пролог-стихотворение, пролог-интерпретация, пролог-поэма, пролог-проза и пролог-рецензия и описал их основные и особенные черты.